



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН
ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ**

2019 оны 6 сарын 10 өдөр

Дугаар 184/ШЗ2019/06724

Улаанбаатар хот

**Эвлэрлийн гэрээг
баталгаажуулах тухай**

Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч
Т.Батсүх би

Өргөдөл гаргагч: “Лэндмн ББСБ” ХК /РД: 5039754/. Хаяг: Сүхбаатар дүүрэг, 5-
р хороо, үндсэн хуулийн гудамж, Ньюмайд групп ХХК-ийн байр

Уригдсан тал: Ноён хангай овогт Равдандоржийн Өлзийсайхан /РД:
А369122803/. Хаяг: Сонгинохайрхан дүүрэг, 7-р хороо, 19-р гудамж, 13 тоот

Зээлийн гэрээний үүрэгт 721,700 /долоон зуун хорин нэгэн мянга долоон зуун/
төгрөг гаргуулахыг хүссэн маргаанд эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр 2019
оны 6 дугаар сарын 3-ны өдөр талуудын байгуулсан 301 дугаартай эвлэрлийн гэрээг
2019 оны 6 дугаар сарын 5-ны өдөр хүлээн авч

ТОДОРХОЙЛОХ нь:

Өргөдөл гаргагч “Лэндмн ББСБ” ХК нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид
гаргасан өргөдөлдөө: Манай байгууллагын харилцагч Р.Өлзийсайхан нь LendMf
аппкейшнээр дамжуулан гаргасан хүсэлтийн дагуу 2018 оны 6 дугаар сарын 29-
ний өдөр 800,000 төгрөгийн зээлийг 71,700 төгрөгийн шимтгэлтэй, 30 хоногийн
хугацаатай 2018 оны 7 дугаар сарын 29-ний өдөр эргэн төлөх нөхцөлтэйгөөр
800,000 төгрөгийг Р.Өлзийсайханы Худалдаа хөгжлийн банкны 458015456 тоот
дансанд шилжүүлсэн. Харилцагч 2018 оны 12 дугаар сарын 7-ны өдөр зээлийн
шимтгэлээс 50,000 төгрөг, 2019 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр мөн шимтгэлээс
21,700 төгрөг, үндсэн зээлээс 78,300 төгрөг нийт 150,000 төгрөгийн төлөлт хийсэн.
Үлдэгдэл үндсэн зээлийг өнөөдрийг хүртэл төлөөгүй байгаа нь зээлийн гэрээний
4.2.2 дахь заалтыг зөрчиж байна. Гэрээний үүргээ биелүүлэх, зээлээ төлөхийг удаа
дараа шаардсан боловч өнөөдрийг хүртэл төлөөгүй байгаа тул Р.Өлзийсайханаас
үлдэгдэл үндсэн зээл болох 721,700 төгрөгийг гаргуулж өгнө үү.

ҮНДЭСЛЭХ нь

Өргөдөл гаргагч “Лэндмн ББСБ” ХК нь зээлийн гэрээний үүрэгт 721,700
төгрөгийг Р.Өлзийсайханаас гаргуулахыг хүссэн байна.

Талууд эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн
гэрээгээр уригдсан тал Р.Өлзийсайхан нь өргөдлийн шаардлага 721,700 төгрөгийг
төлөхийг хүлээн зөвшөөрч, 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор 371,700
төгрөг, 2019 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн дотор 350,000 төгрөгийг, улсын
тэмдэгтийн хураамж 21,880 төгрөгийн хамт “Лэндмн ББСБ” ХК-д бүрэн төлж
барагдуулахаар эвлэрлийн гэрээ байгуулсан байна

Талуудын байгуулсан эвлэрлийн гэрээ Иргэний хуульд нийцсэн, гуравдагч этгээдийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хөндөөгүй байна.

Иймд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт заасны дагуу талуудын байгуулсан эвлэрлийн гэрээг баталгаажуулах нь зүйтэй гэж шүүх үзэв.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74¹ дүгээр зүйлийн 74^{1.7}, 74^{1.8} дахь хэсэгт заасныг удирдлага болгон

ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт заасныг баримтлан тус шүүх дэхь эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр өргөдөл гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч А.Билгүүн, уригдсан тал Р.Өлзийсайхан нарын хооронд 2019 оны 6 дугаар сарын 3-ны өдөр байгуулагдсан 301 дугаартай эвлэрлийн гэрээг баталгаажуулсугай.

2. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7¹ дүгээр зүйлийн 7^{1.1} дэхь хэсэгт зааснаар өргөдөл гаргагчийн улсын тэмдэгтийн хураамжид урьдчилан төлсөн 21,880 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74¹ дүгээр зүйлийн 74^{1.8} дахь хэсэгт зааснаар энэхүү захирамжийг тайлбар гаргагч сайн дураар биелүүлээгүй бол шүүхийн шийдвэрийн нэгэн адил албадан гүйцэтгүүлэхийг талуудад мэдэгдсүгэй.

4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74¹ дүгээр зүйлийн 74^{1.9} дэхь хэсэгт зааснаар маргааныг эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр шийдвэрлэсэн тохиолдолд талууд давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлүүлэхээр гомдол гаргах, тухайн асуудлаар анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргах эрхгүйг дурдсугай.

ШҮҮГЧ



Т.БАТСҮХ